

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ,
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН
2015 ОНЫ 02 ДУГААР САРЫН 18-ААС 5 ДУГААР САРЫН 31 ХҮРТЛЭХ
СУДАЛГАА**

Өргөдөл гомдлын хүрээнд

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАРТ ИРЖ БУЙ
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА**

Зорилго:

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах, санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх үйл ажиллагаа, үр дүнг тооцох, нээлттэй, шуурхай, ил тод байдлыг бүрдүүлэх явдал юм.

Хамрах хүрээ:

Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэж буй Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын байгууллагууд болох үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдээс 2015 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд ирүүлсэн өргөдөл, гомдолд тулгуурлан судалгаа, дүн шинжилгээг хийлээ.

Дээрх хугацаанд Хяналт шалгалтын газарт нийт 184 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс салбар тус бүрээр ангилвал:

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдод хандсан – 94

Даатгалын компанид хандсан – 77

Бичил санхүүгийн байгууллагад хандан ирүүлсэн – 13 өргөдөл, гомдол тус тус ирүүлсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг салбар тус бүрээр өмнөх тайлант хугацаатай харьцуулан харуулбал:

График 1



Дээрх графикаас харахад санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй үндсэн гурван салбаруудад иргэдээс ирүүлж буй нийт өргөдөл гомдлын 51% нь үнэт цаасны салбарт, 42% нь даатгалын салбарт, 7% нь бичил санхүүгийн байгууллагуудад хандан ирж байгаа нь харагдаж байна.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газрын хувьд 2015 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 184 өргөдөл, гомдол ирснээс:

Шийдвэрлэх шатандаа байгаа - 27 өргөдөл, гомдол байна. Үүнээс:

Хугацаандаа, судлагдаж байгаа өргөдөл, гомдол - 27

Хугацаа хэтрэн судлагдаж байгаа өргөдөл – 0

Шийдвэрлэж, хариу өгсөн – 157 өргөдөл, гомдол байна. Үүнээс:


Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл – 154

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл – 3

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 19 хоног байна.

Өмнөх тайлант хугацаан дах өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээллүүдийг харьцуулвал:

График 2



Дээрх графикаас харахад өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийн байдал болон шийдвэрлэлтийн дундаж хугацаа тогтмолжиж байгаа нь харагдаж байна. Мөн өмнөх тайлант хугацаануудад тус бүр нийт 56, 50, 50 өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллажээ.

1. Үнэт цаасны салбарт ирүүлсэн өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 94 өргөдөл гомдол ирснээс хувьцаат компанийн ногдол ашигтай холбоотой өргөдөл 20, брокер, дилерийн компаниар өөрийн эзэмшлийн хувьцааг зөвшөөрөлгүй зарагдсан тухай өргөдөл 76, үнэт цаасны бүртгэлтэй холбоотой тодруулга авах тухай өргөдөл 4 тус тус ирсэн байна.

Харилцагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж дараах мэргэжлийн оролцогч байгууллагуудад харилцагчдын хохирлыг барагдуулах үүрэг өгч заасан хугацаанд үүргийн биелэлтийг ирүүлж ажиллаж байна.


Хүснэгт 1

Үнэт цаасны компани	Нөхөн төлбөрийн хэмжээ	Төлөгдсөн нөхөн төлбөрын дүн
"Санар ҮЦК" ХХК	6,010,000.00	6,010,000.00
"Аргайбэст" ХХК	2,0508,800.00	511,200.00
"Масдак ҮЦК" ХХК	399,000.00	399,000.00
Нийт	9,429,000.00	6,920,200.00

Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 10 брокер, дилерийн компаниудад хувьцаа зөвшөөрөлгүй зарсан тухай өргөдөл, гомдол ирсэн бол тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон 13 брокер, дилерийн компанид хандан ирсэн өргөдөл эзлэж байна. Мөн хувьцаат компанийн бүртгэл болон хаяг байршил, ногдол ашгийн талаарх мэдээлэл авахыг хүссэн хүсэлтүүд ирсээр байна.


Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэж буй мэргэжлийн оролцогч байгууллагуудаар хувьцаа зөвшөөрөлгүй зарагдсан тухай өргөдлүүд дараах үнэт цаасны компаниудад ирж байна.

График 3



Харин үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон дараах нэр бүхий үнэт цаасны компаниудаар өмчлөгчийн зөвшөөрөлгүй хувьцаа зарагдсан тухай өргөдөл ирсээр байна.


График 4



Дээрх графикуудаас харахад үнэт цаасны зах зээлд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэж буй брокер, дилерийн компаниудаар хувьцаа зөвшөөрөлгүй зарсан тухай иргэдээс ирүүлж буй өргөдлийн тоо харьцангуй буурах хандлагатай байна. Харин тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компаниудаар өмчлөгчийн зөвшөөрөлгүй хувьцаа зарсан гэх өргөдлийн тоо өссөөр байгаа нь ажиглагдаж байна.

Харилцагчийн хувьцааг зөвшөөрөлгүй худалдсан тухай өргөдөл үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй доор дурьдсан үнэт цаасны компаниудад түлхүү ирсэн бөгөөд уг үзүүлэлтийг 2015 оны 1-р улирлын нийт арилжаанд эзлэх хувьтай нь харьцуулбал:

График 5




Дээрх харьцуулалтын графикаас харахад харилцагчдаас хамгийн их өргөдөл, гомдол ирүүлж буй "Аргай бэст ҮЦК" ХХК нь 2015 он гарсанаас хойш үнэт цаасны арилжаа бага хийсэн байна.

2. Даатгалын салбарт ирүүлсэн өргөдөл,гомдол:

Даатгалын салбарт тайлант хугацаанд нийт 77 өргөдөл, гомдол ирснээс жолоочийн хариуцлагын болон тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөртэй холбоотой гомдол дараахдаатгалын компаниудад ирсэн байна. Үүнд:

График 6




Харилцагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж дараах нөхөн төлбөрийг даатгалын компаниудаар харилцагчдад төлүүлэн хохиролыг барагдуулсан байна.

Хүснэгт 2

№	Компанийн нэр	Нэхэмжилсэн үнийн дүн	Олговол зохих нөхөн төлбөрийн дүн	Төлөгдсөн нөхөн төлбөрийн дүн
1	"Ард даатгал" ХХК	1,760,800	698,000	698,000
2	"Бодь даатгал" ХХК	126,702,620	16,337,800	12,685,200
3	"Мандал женерал даатгал" ХХК	69,664,289	20,209,572	20,209,572
4	"МИГ даатгал" ХХК	4,901,540	831,540	
5	"Монгол даатгал" ХХК	46,620,867	30,485,548	5,000,000
6	"Номин даатгал" ХХК	17,195,000	6,450,000	5,000,000
7	"Хаан даатгал" ХХК	66,637,509	14,803,380	14,803,380
8	"Практикал даатгал" ХХК	61,000,000		
	"Тэнгэр даатгал" ХХК	48,901,100	2,270,000	2,270,000
	"Монре даатгал" ХХК	4,880,574	4,880,574	4,880,574
	Нийт	443,383,725	92,085,840	65,546,726

Өмнөх тайлант хугацаанд даатгалын компаниудын нөхөн төлбөрийн талаарх ирүүлсэн иргэдийн өргөдлийн тоо хэрхэн нэмэгдснийг график 6-р харуулав.

График 6



3. Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд хандан ирүүлсэн өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 13 өргөдөл гомдол ирүүлснээс банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 7 өргөдөл, гомдол ирсэнбөгөөдхадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотойб өргөдөл, гомдол ирсэн байна.

Үүнд:

Хүснэгт 3

№	Компанийн нэр	Шийдвэрлэгдсэн байдал	Ирсэн өргөдлийн тоо
1	"Бизнесийноргил" ХЗХ	Хянагдаж байна	2
2	"Ю бикапитал ББСБ" ХХК	Холбогдохбайгууллагадхандаж, шийдвэрлүүлэх	1
3	"Вишнфанд" ББСБ ХХК	Мэдээлэлирүүлэхтухай	1
4	"Хамона ББСБ" ХХК	"Хамона ББСБ" ХХК ньмэдээллийгзалруулахтухай	1
5	"Инвесткредит ББСБ" ХХК-нытухай	УБЕГ-ийн ХЭБГ-т хандахтухай	1
6	Зэндэмарвижих ХЗХ	Угасуудлаар УБЕГ-ын ХЭБГ-аастодруулахзөвлөгөөгсөн	1
7	"Гравш" ХЗХ	Хугацаахэтэрсэнзээлолгуулжөгөхтухай өргөдөл хянагдаж байна	1
8	ББСБ-ынтухай	Хянагдаж байна	1
9	"Бидбизнесийгдэмжигч" ББСБ	Хянагдаж байна	1

10	"Хамтыннөхөрлөлийнсан" ХЗХ	Хянагдаж байна	1
11	"Идэрхөгжил" ББСБ	Хянагдаж байна	1

Бичил санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудад хандан ирүүлж буй өргөдөл, гомдолын тоо бусад хоёр салбартай харьцуулвал харьцангуй бага байна.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ,
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТЭС**